

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 26

Улаанбаатар хот

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний тус байгууллагад холбогдох заалтуудын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 2 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилтийг хамруулсан болно.

“Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа гадаадын иргэний хурууны хээ, био мэдээллийн сангаас мэдээлэл унших, оршин суух үнэмлэх олгох системийг хөгжүүлэх, бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай холбох”, “Дэлхийн Монголчууд II цогц арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх” арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж, 100 хувь үнэлэгдсэн байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилт 100 хувь буюу 5 оноотой дүгнэгдлээ.

Цаашид үйл ажиллагааны цахимжилтийг үргэлжлүүлэн, үйлчлүүлэгчийн санал хүсэлт, хэрэгцээ шаардлагад тулгуурлан системийн хөгжүүлэлтийг тухай бүр тогтмол сайжруулах шаардлагатай.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР